

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |  |      |
|------|--|------|
| 251. | Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай | 1194 |
|------|--|------|

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 252. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай              | Дугаар 45 | 1194 |
| 253. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай                       | Дугаар 46 | 1195 |
| 254. | Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай | Дугаар 48 | 1198 |

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

- |      |  |            |      |
|------|--|------------|------|
| 255. | Засгийн газарт чиглэл өгөх тухай                 | Дугаар 92  | 1200 |
| 256. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 96  | 1201 |
| 257. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 97  | 1202 |
| 258. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 98  | 1202 |
| 259. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай        | Дугаар 99  | 1203 |
| 260. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай        | Дугаар 100 | 1203 |
| 261. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай        | Дугаар 101 | 1204 |
| 262. | Элчин сайдыг тохоон томилох тухай                | Дугаар 102 | 1204 |



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

263.	Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 135	1205
264.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 136	1206
265.	Төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөх тухай	Дугаар 138	1207

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2013 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР  
СОНГОГДСОН ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ  
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Цахиагийн Элбэгдоржийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 07 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн  
тангараг өргөх тов тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Цахиагийн Элбэгдорж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийн товыг 2013 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 11 цаг 40 минутад байхаар тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### **Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монголын төрт ёсны уламжлалыг хүндэтгэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолыг шинэчилж ард нийтийн хүртээл болгох шаардлагыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-д дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

#### **1/Хоёрын 15-17 дахь заалт:**

“15.Үүний дараа Ерөнхийлөгч Төрийн ордон дахь Монгол Улсын нэгдсэн тулгар төрийн уламжлалт есөн хөлт Их цагаан туганд хүндэтгэл үзүүлж адис авна.

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан Ерөнхийлөгчийн өргөөнд хүрэлцэн ирж, ажил хүлээлгэн өгөх ёслол болно.

16.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч ажил хүлээлгэн өгөх ёслолын дараа Төрийн тамгыг хадаг /нанжвандан/ дээр залж Ерөнхийлөгчид хүндэтгэлтэйгээр өргөн барина. Ерөнхийлөгч Төрийн тамгыг хүндэтгэлтэйгээр түшиж адислан гардаж аваад ширээн дээр зална.

17.Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагаанд зориулж цэргийн ёслолын жагсаал явуулна.”



2.Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/Нэгийн 1, 2 дахь заалт:**

“1.Төрийн ордон цогцолбор дахь Их эзэн Чингис хааны хөшөө /цаашид “Их эзэн Чингис хааны хөшөө” гэх/-ний баруун гар талд Монгол Улсын төрийн далбааг байрлуулсан байна. Төрийн далбааны дэргэд ам дөрвөлжин цагаан эсгий дэвсэж, хоёр талд Монгол Улсын төрийн ёслолын хүндэт харуулын цэрэг зогссон байна.

Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө талбайн баруун гар талд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга нарт зориулсан ширээ, сандал, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх талбайн зүүн гар талд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарт зориулсан ширээ, сандал, Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх талбайн голд шинээр сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөж, үг хэлэх индэр, талбайн зүүн, баруун жигүүрт Улсын Их Хурлын гишүүдийн суух сандлыг хивсэн дээр тус тус байрлуулсан байна.

2.Их эзэн Чингис хааны хөшөөний өмнөх талбайн голд байрлуулсан индэр дээр Үндсэн хуулийн уг эх хувь, шинээр сонгогдсон Ерөнхийлөгчид зориулсан ширээн дээр Ерөнхийлөгчийн тангараг бичиг, гарын үсэг зурах үзэг болон бэх тавьсан байна.”

**2/Нэгийн 5 дахь заалт:**

“5.Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Ерөнхий прокурор болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлага болон хэвлэл, мэдээллийн ажилтнууд, иргэдийн төлөөлөл, гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн, зочдыг урьсан байна.”

**3/Хоёрын 7, 8 дахь заалт:**

“7.Ийнхүү зарламагц Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслолын албаны даргыг дагуулан тангараг өргөх ёслолын талбайд хүрэлцэн ирж, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж



байгаа Ерөнхийлөгч түүнд зориулсан ширээний ард, шинээр сонгогдсон Ерөнхийлөгч өөрт нь зориулсан ширээний ард зогсоно.

8.Ерөнхийлөгч индэрт гарч Үндсэн хуулийн уг эх хувь дээр баруун гараа тавиад тангаргийг цээжээр дээдлэн дуудаж, ширээнээ эргэн очиж тангарагт гарын үсгээ зурна. Дараа нь Улсын Их Хурлын даргад тангараг бичгээ гардуулна. Ийнхүү тангараг бичгээ гардуулсны дараа Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлээд, Төрийн далбааны дэргэд очиж ам дөрвөлжин цагаан эсгий дээр зүүн өвдөг сөгдөн Төрийн далбаанаас адис авна.”

#### **4/Хоёрын 12 дахь заалт:**

“12.Ерөнхийлөгч улиран сонгогдсон тохиолдолд Ерөнхийлөгч Тамгын газрын даргаа дагуулан Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө хүрэлцэн ирж энэ журамд заасны дагуу тангараг өргөнө.

Ерөнхийлөгч улиран сонгогдсон тохиолдолд ажил хүлээлцэх, Төрийн тамгыг гардуулах ёслол үйлдэхгүй.”

3.Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын Нэгийн 4 дэх заалтын “Их танхимд” гэснийг “Төрийн ордон цогцолборын өмнө, тусгай зассан талбайд” гэж, Хоёрын 11 дэх заалтын “9 дүгээр зүйлд” гэснийг “Хоёрын 16 дахь заалтад” гэж, Хоёрын 13 дахь заалтын “Төрийн тамгыг ширээн дээрээ залмагц” гэснийг “ширээндээ залармагц” гэж, мөн заалтын “Их танхимд” гэснийг “ёслолын ажиллагаанд оролцож” гэж, Хоёрын 14 дэх заалтын “иргэдийг төлөөлөн” гэснийг “иргэдийн төлөөлөл баяр хүргэж үг хэлсний дараа” гэж, мөн заалтын “хандаж үг хэлнэ” гэснийг “хандаж индэрт үг хэлнэ” гэж, Хоёрын 15 дахь заалтын дугаарыг “18” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх ёслолын журам”-ын Хоёрын 9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тогтоолыг 2013 оны 7 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 07 дугаар  
сарын 03-ны өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

### Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл;

2/Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл;

3/Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн төсөл;

4/“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2014 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/Газрын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

6/Газрын кадастрын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

7/Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

9/“Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

10/Монгол Улсын сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл;

11/Улс төрийн намын тухай, Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

12/Татварын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



13/Монгол Улсын 2014-2018 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр батлах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

14/Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл;

15/Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл;

16/Ашигт малтмалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

17/Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

18/Газрын тосны тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

19/Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

21/Нийтийн албаны тухай хуулийн төсөл;

22/Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

23/Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

25/Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

26/Олуулаа болох тухай хуулийн төсөл;

27/Баялгийн сангийн тухай хуулийн төсөл;

28/“Төрийн батлан хамгаалах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;



29/“Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

30/“Эрдэс баялгийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

31/бусад.

2.Энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл 2013 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Улсын Их Хурлын даргад зөвшөөрсүгэй.

4.Улсын Их Хурлын 2013 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/, Байнгын хороод, Улсын Их Хурал дахь намын бүлэг болон Тамгын газар /Б.Болдбаатар/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2013 оны 06 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 92

Улаанбаатар  
хот

### **Засгийн газарт чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасан Монгол Улсын иргэний журамт үүрэг болох “Эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах” заалтыг хэрэгжүүлж, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “иргэдэд эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх” үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай:





1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй 18-25 насны, хугацаат цэргийн алба хаагаагүй тус улсын иргэн эрэгтэйчүүдийг оршин суугаа нутаг дэвсгэр, суралцаж буй мэргэжлээс үл хамааран сургалтын чөлөөт цагт нь цэргийн жинхэнэ албыг хаалгахтай холбогдсон эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Хоёр. Зарлигийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авахыг Засгийн газар (Н.Алтанхуяг)-т чиглэл болгосугай.

Гурав. Зарлигийн хэрэгжилтийн талаар жил бүрийн 12 дугаар сард багтаан Монгол Улсын Ерөнхийлөгчид болон олон нийтэд мэдээлэл хийж байхыг Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагад тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

## **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 96

Улаанбаатар  
хот

### **Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Мексикийн Нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хасбазарын Бэхбатыг эгүүлэн татаж, Мексикийн Нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Булгаагийн Алтангэрэлийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 97

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Серби Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Омбоосүрэнгийн Эрдэнэчимэгийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Серби Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Төгсжаргалын Гандиг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Саудын Арабын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашдоржийн Баярхүүг эгүүлэн татаж, Саудын Арабын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содномын Энхбатыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 99

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Латви Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Латви Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Адъяагийн Ганбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 100

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Украин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Украин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Адъяагийн Ганбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 101

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Адьяагийн Ганбаатарыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 07 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 102

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Мозамбик Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Одонжилийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар  
хот

### **Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай**

Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоол, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шинээр баригдаж бүрэн ашиглалтад орсон, 80 м<sup>2</sup>-аас дээшгүй талбай бүхий орон сууц эсхүл ашиглагдаж байгаа хуучин орон сууц худалдан авах хүсэлт гаргасан, тухайн орон сууцны үнийн дүнгийн 10-30 хувиас доошгүй урьдчилгаа төлбөр төлсөн иргэнийг жилийн 8 (±1) хувийн хүүтэй, 20 хүртэлх жилийн хугацаатай, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах журмыг Засгийн газраар батлуулж, арилжааны банкаар дамжуулан ипотекийн зээл иргэдэд олгох ажлыг зохион байгуулахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайханд даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

2. Орон сууцны нийлүүлэлтийг дэмжих зорилгоор ашиглалтад оруулахаар төлөвлөсөн, нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа орон сууцны барилгын судалгааг үндэслэн үе шаттайгаар санхүүжүүлэх ажлыг арилжааны банкаар дамжуулан зохион байгуулахыг Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.

3. Ипотекийн зээлээр орон сууц худалдан авах боломжгүй иргэдэд зориулсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, эхний ээлжинд 1300 айлын түрээсийн орон сууцыг 2013 онд барих ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт даалгасугай.

4. Ипотекийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.



5. Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгон ипотекийн хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, Нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Баярсайхан нарт даалгасугай.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Иргэдийг орон сууцжуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 138 дугаар тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 341 дүгээр тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдах орон сууцны жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 82 дугаар тогтоол, “100 мянган айлын орон сууц” хөтөлбөрт хамрагдах орон сууцны жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2012 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 206 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Ц.БАЯРСАЙХАН**

**ЭДИЙН ЗАСГИЙН  
ХӨГЖЛИЙН САЙД**

**Н.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 4 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:



“Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 199 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ”-ний 17.1.5 дахь заалтад “1 000 000” гэснийг “400 000” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Ц.БАЯРСАЙХАН**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2013 оны 4 дүгээр  
сарын 13-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар  
хот

### **Төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөх тухай**

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор, Төсвийн тухай хуулийн 17.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Соёл, спорт, аялал жуулчлалын яамны “Палеонтологи, археологийн музейн шинэчлэл” төсөл хэрэгжүүлэх тухай саналыг зөвшөөрч, уг төслийн хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэлд даалгасугай:

а) музейн үзмэрт шилжүүлэх шаардлагатай палеонтологи, археологийн олдвор, үзмэрийг эрэн сурвалжилж, бүртгэх, цуглуулах ажлыг олон нийт, олон улсын мэргэжилтнүүдийн оролцоо дэмжлэгтэйгээр гадаад, дотоодод зохион байгуулах;

б) музейн барилгын төлөвлөлт, үзмэрийн дэглэлтийг олон улсын стандартын дагуу хийх бэлтгэл ажлыг хангах;

в) төслийн эхний санхүүжилтийг төсвийн багц дахь соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах зардлаас гаргаж, цаашид төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх;



г) төслийн нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, гэрээ байгуулан, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Ц.ОЮУНГЭРЭЛ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1

**Индекс: 14003**